



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

“Дархан гурил тэжээл” ХК-ийн
үнэт цаасны арилжааг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Дархан гурил тэжээл” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2012 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. “Дархан гурил тэжээл” ХК-ийн хувьцааг арилжаалж эхлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001517